

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн 30 дугаар хуралдааны тэмдэглэл /2013-03-06/**

Ажлын хэсгийн хуралдаан 2013 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 15 цагт Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Уул уурхайн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга н.Хүрэлбат, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төсөл хариуцсан мэргэжилтэн Б.Хулан, Ашигт малтмалын газрын хэлтсийн дарга Б.Бямбадагва, мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Үндэсний татварын ерөнхий газрын Эрдэс баялгийн татварын хэлтсийн ахлах байцаагч х.Батчимэг, байцаагч Д.Энхтуяа, Бороо Гоулд ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч х.Өнөржаргал, нягтлан бодогч х.Азжаргал, Монголын геологийн холбооны мэргэжилтэн н.Тодбилэг, Эрдэнэс ТТ ХХК-ны мэргэжилтэн Д.Санчир, Монголын уул уурхайн ассоциацийн олон талт хамтын ажиллагааны мэргэжилтэн н.Батбилэг, Оюу толгой ХХК-ийн олон талт хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөний тэргүүн Б.Баярмаа, Байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг, МБОИЗ-ийн менежер хСаранггоо, Онон улз голынхон хөдөлгөөний тэргүүн Л.Отгонцэцэг, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож ирц 52 хувьтай байв.

Мөн хуралдаанд ОУИТБС-ын Нийслэлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, НЗДТГ-ын Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн х.Содцэцэг, Үндэсний зөвлөлийн гишүүн Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүү, захиргааны ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Ажлын хэсгийн хуралдааныг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ш.Цолмон нээж “Сайн байцаана уу. Гансүх дарга хуралд ирнэ гэж байсан боловч ажил гарсан юм болов уу утас нь болохгүй байна. Хурал эхлэх цаг өнгөрөөд 15 минут болж байгаа тул хэдүүлээ хурлаа эхэлж байх уу. Өнөөдөр 7 асуудал хэлэлцэнэ. Та бүхэнд хэлэлцэх асуудал болон дотоод журамд хэлэх санал байна уу?

Н.Дорждарь: Нэг санал байна. Хэлэлцэх асуудалдаа бусад гэсэн асуудал нэмж оруулая. Би ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны хуралд оролцоод ирсэн, тэр талаар товч мэдээллийг та бүхэнд өгөх гэсэн юм.

Ш.Цолмон: За тэгье, хэлэлцэх асуудлын 8 дугаарт нь бусад асуудал гэж оруулая. Өөр санал байхгүй бол хурлаа эхлээ.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны 2012 оны төлөвлөгөөний биелэлт

Ш.Цолмон: Танилцуулгаа эхлэхээс өмнө та бүхэнд товчхон мэдээлэл хийх гэсэн юм. Манай ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нь 2 дугаар сарын 1-нээс харилцааны мэргэжилтнээр ажиллах болсон байгаа. Шинээр санхүү, захиргааны туслах ажилтныг нээлттэй сонгон шалгаруулж,

А.Отгонтунгалаг гэх энэ эмэгтэй маань энэхүү ажлын байранд тэнцэж, манайд шинээр ажиллах болсон. Отгонтунгалаг нь Дэлхийн банкны Боловсролын яамны төсөл дээр ажиллаж байсан туршлагатай ажилтан байгаа. Ингээд ажлын алба маань З хүнтэйгээр бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна.

Одоо хэлэлцэх асуудлын дагуу 2012 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг товч танилцуулъя. 2012 онд олон ажлыг хийхээр төлөвлөж, ихэнх ажил нь хуваарийн дагуу хийгдсэн, зарим төлөвлөсөн ажлууд Европын сэргээн босголт хөгжлийн банкны техник туслалцааны төслийн төлөвлөгөөтэй уялдан хойшлогдсон байгаа. Тайланг та бүхэнд урьдчилан тараасан тул 2012 онд хийгдсэн томоохон ажлуудыг дурьдая. **Нэгдүгээрт**, ОҮИТБС-ын 2011 оны нэгтгэлийн тайланг амжилттай хэлэлцэн баталлаа. 2011 оны ОҮИТБС-ын тайлангаа 301 компани гаргаж, Засгийн газар 518 компаниар гаргаж, үүнээс 200 компанийд аудит хийв. Нэгтгэлд хамрагдсан 200 компани нийт 2,1 их наяд төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төлж, үүнээс 622 сая төгрөг нь тайлбарлагдахгүй, зөрүүтэй үлдэв. **Хоёрдугаарт**, 2012 оны 7 дугаар сард Засгийн газрын 222 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 62 тоот захирамжийг гаргууллаа. Энэхүү тогтоолоор ОҮИТБС-ын хэрэгжилтийн үр дүнг сайжруулахад чиглэсэн зарим арга хэмжээ авч ажиллахыг холбогдох газруудад үүрэг өгсөн бөгөөд 3 талын төлөөллийг томилон ажиллуулах шинэ журам гаргасан нь томоохон өөрчлөлт болов. **Гуравдугаарт**, гадаад хамтын ажиллагааны тухайд ОҮИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шорт Монгол Улсад айлчилж, уг айлчлалыг зохион байгуулав. Энэхүү айлчлал нь өндөр ач холбогдолтой, чухал айлчлал байв. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Норвегийн вант улсад хийх айлчлалын үеэрээ ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын удирдлагуудтай уулзалт хийж, ОҮИТБС-ын хэрэгжилтийн талаар санал, мэдээлэл солилцсон. Энэхүү уулзалтыг хийхэд ажлын албанаас шаардлагатай зохицуулалтыг хийсэн болно. **Дөрөвдүгээрт**, Үндэсний зөвлөлийн 2 удаагийн, Ажлын хэсгийн 4 удаагийн хурлыг зохион байгуулж, шаардлагатай шийдвэр, тогтоолуудыг гаргуулан, чиглэл өгч ажиллав. **Тавдугаарт**, ажлын албаны цахим хуудсыг шинэчлэн сайжруулж, улам боловсронгуй болгов. Мөн ОҮИТБС-ын гишүүн орнуудын дунд зарласан видео киноны уралдаанд оролцож, богино хэмжээний видео кино хийв. **Зургадугаарт**, ОҮИТБС-ын тайлангийн маягтыг шинэчлэн Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар баттуулсан болно. За товчхондоо бол иймэрхүү байна. Олон ажил эхлүүлсэн ч Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төслийн завсардалаас шалтгаалан олон ажил хойшилсон байгаа. Энэ асуудлын талаар санал, асуулт байвал асууж болно. /Танилцуулгыг хавсаргав/

Н.Дорждарь: Тайланг уншиж танилцлаа. Энд бол зөвхөн хийсэн ажлууд болон хийгээгүй зүйлээ жагсааж бичсэн байна. Энэ нь тийм ч хангалттай биш юм. Үүнд санхүүжилт зарцуулалтын талаар товч оруулж өгвөл зүгээр юм. Энэ удаа одоо яах вэ, цаашдаа анхааралдаа аваарай.

Ш.Цолмон: За, санхүүжилтийн талаарх мэдээллийг дараагийн тайландаа оруулж өгье.

Б.Дэлгэрмаа: 2012 онд Дэлхийн банкны Итгэлцлийн сангаас (нийт 250,000 ам.долларын буцалтгүй тусламжийн гэрээ) 70,000 ам.долларыг үйл ажиллагааны зардалд, улсын төсвөөс 200 орчим сая төгрөгийг аудитын нэгтгэлийн ажлын зардалд тус тус зарцуулсан байгаа.

н.Тодбилэг: ОҮИТБС-ын тайланд нөөцийн нөхөн үйлдвэрлэлийн биелэлт, зарцуулсан хөрөнгө зардлын талаарх мэдээлэл ордог уу. Энэ нь геологи хайгуулын зардалд ордог зардал юм. Тайлангийн маягтад ямар хэлбэрээр орсон бэ?

Ш.Цолмон: Яг мэргэжлийн үүднээс энэ зардал нь геологи хайгуулын зардалдаа ордог эсэхийг сайн мэдэхгүй байна. Гэхдээ асууж тодруульяа.

Н.Баярсайхан: Тайланг хараад зөвхөн хийсэн ажлын жагсаалт л харагдаж байна. Бид дараагийн хурлаар бас л ийм юм сонсоод суух нь учир дутагдалтай байна. Тиймээс ажлын биелэлтийн тайландаа ямар зорилт тавьсан, тулгарсан саад бэрхшээлүүд юу байв, биелэлт нь хэдэн хувьтай байв гэх мэт илүү дүгнэлт талдаа баймаар байна. Мөн Засгийн газрын 222 дугаар тогтоолын биелэлт, ОУЫН дүрмийн биелэлт, Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар заалтын биелэлт гэх зэргийг тайланд оруулж өгөх нь зүйтэй. Тайланг жилдээ 1 удаа биш 6 сар тутамд ч юм уу хэлэлцэж байвал ясан юм бэ?

Б.Баярмаа: Ажлын биелэлтийн мониторинг, хяналтийг яаж хийж байна вэ? Төлөвлөгөөг илүү хяналттай, мониторингтой биелүүлэх хэрэгтэй. Энэ оны 9 сард ч юмуу мониторинг, үнэлгээний хурал хийх хэрэгтэй.

Ш.Цолмон: За, чухал санал хэлсэнд баярлалаа, саналуудыг тусгаад явъя.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монголын ОҮИТБС-ын ажлын албаны 2012 оны төлөвлөгөөний биелэлтийг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн, цаашид биелэлтийн тайлангаа гишүүдийн гаргасан саналыг тусган боловсруулж байхаар тогтов.

2. ОҮИТБС-ийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үнэлгээг 2013 оны 9 дүгээр сард Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэхээр тохиролцов.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл

Ш.Цолмон: Монголын ОҮИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг мөн та бүхэнд урьдчилан имэйлээр хүргүүлсэн байгаа. 2013 оны ажлын төлөвлөгөөний онцлох зүйлсийг товчхон дурьдвал: Монгол Улсын ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэл тайланг уламжлал ёсоор 2013 оны 11 дүгээр сард багтаан гаргах, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн үйл ажиллагааг улам идэвхжүүлэх зорилго тавин ажиллаж байна. Тухайлбал Үндэсний зөвлөлийн хуралдааныг 4 дүгээр сард хуралдуулж хуулийн төслийг хэлэлцэх төлөвлөгөөтэй байна. Мөн 2012 онд хийгдэж чадаагүй олон ажлуудыг хэрэгжүүлэх ялангуяа харилцаа, сургалт, сурчилгааны ажлыг түлхүү хийхээр төлөвлөж байна. За түүнчлэн Европын сэргээн босголт хөгжлийн банкны төслийн үйл ажиллагааг энэ онд эрчимтэй урагшуулахаар төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал энэ оны 3 дугаар сарын 18-наас 3 дугаар сарын 29, 4 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 3-ны өдрүүдэд хуулийн зөвлөх багийнхан ирж ажиллана. Энэ хугацаанд ОҮИТБС-ын хуулийн төслийг нилээн явуулах болов уу гэж бодож байна. За дээр нь ОҮИТБС-ын 2012 оны нэгтгэлийн тайлангийн тендерийн үнэлгээний хорооны ажлыг эрчимжүүлэх, Сиднейн бага хуралд оролцох бэлтгэл ажлыг хангах, 2012

оны ОҮИТБС-ын тайлан гаргах ажлыг эрчимжүүлэх, орон нутагт дэд зөвлөл байгуулах ажлыг эхлүүлэх гэх зэрэг олон ажил төлөвлөсөн болно. За асуух асуулт, саналтай хүн байна уу? /2013 оны төлөвлөгөөний төсөл, танилцуулгыг хавсаргав/

Н.Баярсайхан: 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж байх нь зүйтэй. Мөн олон нийтэд чиглэсэн ажлыг түлхүү хийх хэрэгтэй байна. Төлөвлөгөөний биелэлтийг хагас жилд 1 удаа хэлэлцэх нь зүйтэй.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монголын ОҮИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд гишүүдийн гаргасан саналыг тусган батлахаар тогтов.

2. Монголын ОҮИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хагас жилд нэг удаа хэлэлцэхээр тогтов.

3. Монголын ОҮИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг ягштал баримтлан ажиллахыг ажлын алба, бүх гишүүдэд анхааруулав.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2013 оны харилцаа, суртчилгааны төлөвлөгөөний төсөл

Ш.Цолмон: Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2013 оны харилцаа, суртчилгааны төлөвлөгөөний төслийг ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа танилцуулна.

Б.Дэлгэрмаа: За баярлалаа. Миний хувьд ажлын албанд санхүүгийн мэргэжилтнээр 2010 оноос хойш ажиллаж байгаад 2013 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн харилцааны мэргэжилтнээр ажиллах болсон. Төлөвлөгөөний төслийг та бүхэнд урьдчилан тараасан байгаа тул гол гол зүйлсийг дурьдаад явъя. Энэ онд ОҮИТБС-ийн талаарх мэдээллийг түгээх, сурталчилгааны төлөвлөгөөний төслийг ажил хийхээр төлөвлөсөн болно. Мэдээллийг түгээх, сурталчилгааны төлөвлөгөөний төслийг ажил хийхээр төлөвлөсөн болно. Мэдээллийг түгээх, сурталчилгааны төлөвлөгөөний төслийг ажил хийхээр төлөвлөсөн болно. Мэдээллийг түгээх, сурталчилгааны төлөвлөгөөний төслийг ажил хийхээр төлөвлөсөн болно. Харилцаа, сурталчилгааны хүрээнд бид 6 үндсэн зорилт дэвшүүлсэн. Зорилт бүр дээр хийгдэх гол ажлуудыг танилцуулаад явъя. (Танилцуулгыг хавсаргав)

Ш.Цолмон: За асуух асуулт байна уу?

Д.Энхтуяа: Төрийн байгууллагуудын тайлан гаргадаг ажилтнуудад зориулсан сургалтыг 4 дүгээр сард хийхээр төлөвлөсөн байсан. 2012 оны тайланг ерөнхийд нь аваад дуусч байгаа учраас үүнийг хойшлуулвал ясан юм бэ? 2013 оны тайлан гаргахаас өмнө 2013 оны 11 сард ч юмуу хийвэл илүү үр дунтэй байх гэж бодож байна. ОҮИТБС-ын Засгийн газрын тайланг гаргадаг ажилтнууд их солигддог тул тайланг чанаргүй гаргах тохиолдол маш олон байдаг тул ийм төрлийн сургалт зохион байгуулах нь чухал ач холбогдолтой.

Д.Мөнхсайхан: Харин тийм, сургалт хийхээр дараа тайлан гаргах болтол бараг дахиад мартчих байхаа. Хойшлуулаад 11,12 сард болгох нь зүйтэй юм.

Ш.Цолмон: Тэгвэл хуваарь дээрээ өөрчилье. Өөр санал, асуулт байна уу?

Б.Бямбадагва: Надад нэг санал байна. Тэр Transparency award гэдгийг хийх хэрэг байна уу. ОҮИТБС-ын тайлан гаргах нь хуулийн хүрээнд заавал гаргаж байх үүрэг учраас ийм зүйлийн хэрэг байна уу?

Н.Баярсайхан: Орон нутагт ОҮИТБС-ын дэд зөвлөл байгуулах гэдэг ажил дээр хамтран ажиллах талууд дээр нь ТАН эвсэл гэж оруулах нь зүйтэй. Бид орон нутагт ТАН эвслийн олон гишүүд байгаа тул дэд зөвлөл байгуулахад оролцоод явах нь зүйтэй.

Х.Лхамаа: Олон улсад сурталчилах гэдэг дээр юу хийх гэж байна?

Б.Дэлгэрмаа: Үүнд 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зүйлс байгаа. Тухайлбал Сиднейн бага хуралд оролцох бэлтгэл ажлыг хангах, гадаад улсуудтай туршлага солилцох, Монгол улсад айлчлах ОҮИТБС-ын гишүүн орнуудын, олон улсын нарийн бичгийн дарга нарын айлчлалыг зохион байгуулах гэх зэрэг ажлууд орсон байгаа.

Н.Баярсайхан: Орон нутагт мэдээллийн төв байгуулах гэж дурьдлаа. Үүн дээрээ сайн анхаарах хэрэгтэй. Хоосон цоожтой хаалга болох вий. Илүү үр дүнтэй байх талаас нь анхаараарай.

Х.Лхамаа: Мэдээллийн төвийг шинээр байгуулах гэхээсээ илүү байгаа бэлэн төвүүдийг ашиглах нь зүйтэй байха. Ханбогд сум дээр жишээ нь манай Оюу толгой ХХК-ийн тохижуулсан бэлэн танхимууд байгаа, үүн дээр тараах материалыа байрлуулах зэргээр ашиглаж болно шүү.

Х.Өнөржаргал: Надад нэг санал байна. Тэр Transparency award гэдэг арга хэмжээг зохион байгуулах нь компаниуд бидний хувьд их чухал ач холбогдолтой гэж бодож байна. Татварыг ч гэсэн бид заавал тайлангаа өгөх үүрэгтэй ч “шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгж” гэдэг цом, өргөмжлөл гардуулдаг. Энэ нь бидэнд нийгэмд ямар байр суурьтайг нотлон харуулах нэр төрийн хэрэг болдог учраас ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэгч гэдэг утгаараа тийм өргөмжлөл байх нь ач холбогдолтой гэж бодож байна.

Х.Батчимэг: Компаниуд тийм өргөмжлөл өгч байгаа бол Засгийн газрын тайланг гаргадаг байгууллагуудыг ч бас урамшуулах хэрэгтэй.

Н.Дорждарь: Яахав тэр Transparency Award гэдэг санаа дээр татгалзах зүйл алга. Гэхдээ дан ганц тайлан гаргадаг гэдгээр нь бус өөр олон үзүүлэлтээр шалгуур тавих хэрэгтэй. Хэрэв яг ийм өргөмжлөл гардуулна гэж төлөвлөж байгаа бол эртхэн тэр шалгуур үзүүлэлтээ сайн гаргах хэрэгтэй.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2013 оны харилцаа, сурталчилгааны төлөвлөгөөг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцээд, гишүүдийн гаргасан саналыг тусган батлав.

IV. ХЭЛЭЛЦСЭН нь: Компаниудын ОҮИТБС-ын 2012 оны тайлан гаргах ажлын явц

Ш.Цолмон: За компаниудын ОҮИТБС-ын 2012 оны тайлан гаргах ажлын явцын талаар Ашигт малтмалын газрын Статистик, судалгааны хэлстийн дарга Б.Бямбадагва танилцуулна.

Б.Бямбадагва: Манай байгууллагын кадастрын нэгдсэн мэдээллийн санд 2012 оны байдлаар 1827 ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, нөгөө талаар ашиглалтын 1237, хайгуулын 2300 тусгай зөвшөөрлүүд тус тус бүртгэгдсэн байна. Тусгай зөвшөөрөл бүхий 1827 аж ахуйн нэгжээс 2013 оны 3 дугаар сарын 5-ны байдлаар ашиглалтын лиценз бүхий 155 компани, хайгуулын лиценз бүхий 113 компани, нийт 268 компани ОҮИТБС-ын 2012 оны тайлангаа гаргасан байна. Тайлангаа ирүүлээгүй 1559 аж ахуйн нэгжүүд рүү 2013 оны 3 дугаар сарын 15-ны дотор тайлангаа гаргах тухай албан тоотыг хүргүүлэхээр Ашигт малтмалын газар ажиллаж байна. Ингээд 3 сарын 15-ны дотор тайлангаа ирүүлээгүй аж ахуйн нэгжийн нэrsийн жагсаалтыг МХЕГ-т хүргүүлэхээр төлөвлөж байна. За тайланг чанартай гаргуулах үүднээс ОҮИТБС-ын ажлын албатай хамтран 2 дугаар сарын 6-ны өдөр 65 аж ахуйн нэгжийн 78 ажилтнуудад сургалт зохион байгуулав. 3 дугаар сард мөн 100 аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. /Танилцуулгыг хавсаргав./

Х.Тодбилэг: Тайлан гаргах ямар эрх зүйн үндэс байна вэ? тайлангаа гаргаагүй бол ямар хариуцлага тооцох вэ?

Б.Бямбадагва: Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар заалтад заавал тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүн, төлсөн татвар төлбөрийнхөө хэмжээг тайлагнана гэж заасан байдаг. Хэрэв энэ заалтыг хэрэгжүүлээгүй бол хуулийн дагуу 500,000-1,000,000 хүртэлх төгрөгөөр торгох, бүр цаашилбал мэдээ тайлант удаа дараа ирүүлээгүй гэдэг заалтаар тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах боломжтой. Энэ талаар МХЕГ-тай ярилцсан байгаа.

Х.Батчимэг: За Ашигт малтмалын газраас Засгийн газрын тайландаа орох компаниудын нэrsийг 2012 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар лиценз эзэмшиж буй байдлаар нь гаргаж 1827 аж ахуйн нэгжийн нэrsийг Татварын ерөнхий газар ирүүлсэн. Гэтэл үүн дээр нэг асуудал байна. 2012 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31-ны хооронд тухайн компани лицензээ зарсан, шилжүүлсэн байвал манай дээр тайлан гаргахад хүндрэлтэй болж байгаа юм. Ашигт малтмалын газраас гаргаж өгч буй энэ нэrsийн жагсаалт нь учир дутагдалтай байна гэж бодож байна.

Б.Бямбадагва: Бид 2012 оны тайлан гаргаж байгаа юм чинь он цагийн хувьд 12 сарын 31-нээр тасалбар болгож авах нь зөв. Тэр аж ахуйн нэгж лицензээ шилжүүлж болно, гэхдээ татвар, төлбөр төлсөн бол танайд тайлангаа өгөх учир түүгээр нь тайланг нь гаргаж болно гэж ойлгож байна. Лицензийн хөдөлгөөний бүх мэдээг бид гаргаж явдаг.

Н.Дорждарь: Тайланд хамрагдах тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн тоо зөрүүтэй байгаад байх юм. Яг энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажлын хэсэг байгуулах нь зүйтэй.

Ш.Цолмон: За тэгье. Ажлын хэсэгт АМГ-ын Б.Бямбадагва, ТЕГ-ын Д.Энхтуяа, Н.Дорждарь, за тэгээд манай ажлын албанаас төлөөлөл оролцоод ирэх долоо хоногт уулзалт зохион байгуулая.

Б.Бямбадагва: АМГ-аас кадастрын бүртгэлийн хэлтсээс нэг хүн байлцуулах нь зүйтэй байх.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Компаниудын ОҮИТБС-ын 2012 оны тайлан гаргах ажлыг эрчимжүүлж, З дугаар сарын 15-наас өмнө тайлан гаргах тухай сургалтыг АМГ, ажлын албатай хамтран зохион байгуулахаар тогтов.

2. Засгийн газрын ОҮИТБС-ын 2012 оны тайланда хамрагдах аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг АМГ, ТЕГ, ТАН эвслийн төлөөллийг оролцуулан байгуулж, үр дүнг Ажлын хэсэгт танилцуулж ажиллахаар тогтов.

V. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2006-2011 оны нэгтгэлийн тайлангийн зэрэгцүүлсэн судалгааны дүн, ажиглалт

Ш.Цолмон: Монгол Улсын ОҮИТБС-ын 2006-2011 оны нэгтгэлийн тайланда хийсэн судалгааны дүнг ОҮИТБС-ын Олон улсын удирдах хорооны гишүүн, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүн Н.Дорждарь танилцуулна.

Н.Дорждарь: За баярлалаа. ТАН эвсэл, Нээлттэй нийгэм форум Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр ОҮИТБС-ын 2006-2011 оны нэгтгэлийн тайлангаар бий болсон мэдээлэл, өгөгдөл дүн шинжилгээ хийж, “Өгөгдлийн уурхай” гэсэн эмхэтгэл тайланг хэвлэн нийтэллээ. Судалгааны гол зорилго нь санаачилгын тайлангаас орон нутгийн иргэд хүссэн мэдээллээ олж авч боломжтой ю? гэдэгт үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршсон. Судалгааны тайланг та бүхэнд тараасан тул гол гол зүйлсийг товчхон дурьдаад явъя. /Танилцуулга, “Өгөгдлийн уурхай” судалгааны тайланг хавсаргав./

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2006-2011 оны нэгтгэлийн тайланда хийсэн судалгааны тайлантай ажлын хэсгийн гишүүд танилцаж, сайшаан Үндэсний зөвлөлд танилцуулахаар тогтов.

2. Судалгааны тайлан болох “Өгөгдлийн уурхай” эмхэтгэлийг цааш сурталчилан таниулахыг бүх гишүүдэд зөвлөмж болгов.

VI. ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

Ш.Цолмон: За Дорждарь үргэлжлүүлээд бусад асуудлаа танилцуулаад явъя.

Н.Дорждарь: За тэгье. Миний хувьд сая 2 дугаар сард ОҮИТБС-ын Олон улсын удирдах хорооны хуралд оролцоод ирлээ. Тэнд хэлэлцсэн гол гол асуудлыг та бүхэнд мэдээлэх гэсэн юм. ОҮИТБС-д сайн дураар нэгдсэн 34 орон байдаг ба шинээр Тажекстан улс элсэн орлоо. За нөгөөтэйгүүр тайлангаа хугацаанд нь гаргаагүй зарим улсуудын эрхийг түр түдгэлзүүлсэн болно. Гол хэлэлцсэн зүйл гэвэл Олон улсын дүрэмд зарим өөрчлөлтүүдийг орууллаа. Үүнд:

бүтээгдэхүүний хэмжээ, төслийн ил тод болгох, лицензийн ил тод байдлыг хангах, цаашид орлогын хуваарилалтыг ил тод болгох, санаачилгын үндсэн тайлагналын механизмыг Засгийн газар нь мэдээллийн системдээ хэрхэн уялдуулж байгаа талаар тодорхой тайлагнаж байхаар болсон. Мөн нийгмийн хөгжилд зарцуулсан зарцуулалт, бүтээгдэхүүн хуваарилалтын гэрээ, лицензийн мэдээллийг ялангуяа цаад ээний талаар нийтэд мэдээлэх, ИНБ-ийн оролцоо зэрэг мэдээллийг тайлагнаж байхаар боллоо. Санаачилгын баталгаажуулалтыг Олон улсад нэгдсэн журмаар 5 жилд нэг удаа хийдэг байсныг 3 жилд нэг удаа хийж байхаар боллоо. Баталгаажуулалтын 21 шаардлага байсныг 7 болгож, санхүүжилтүүг тухайн орны Засгийн газар нь даадаг байсан бол одоо зардлыг Олон улсаас нэгдсэн журмаар санхүүжүүлэхээр болсон.

Ш.Цолмон. За их сонирхолтой мэдээлэл хийсэнд баярлалаа. Одоо дараагийн асуудалдаа орье.

VII. Засгийн газрын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2012 оны тайлан гаргах ажлын явц

Ш.Цолмон. Засгийн газрын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2012 оны тайлан гаргах ажлын явцын талаар ТЕГ-ын улсын байцаагч Д.Энхтуяа танилцуулна.

Д.Энхтуяа: За баярлалаа. 2012 оны тайланд АМГ-аас ирүүлсэн 1850 компанийг хамруулсан. 2012 оны тайланг төрийн 43 яам агентлаг гаргах ёстойгоос 37 байгууллага тайлангаа хугацаанд нь ирүүлсөн бөгөөд тайлангийн явц 86 хувьтай байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Сорьцын алба, Орхон аймгийн ЗДТГ,Өмнөговь аймгийн ЗДТГ, Багануур дүүрэг зэрэг газрууд тайлангаа гаргаагүй, эсхүл дутуу гаргасан байна.

Тайлан гаргах ажлыг хөнгөвчлөх зорилгоор ТЕГ-аас тусгай программ бий болгож, цахим хандалттай болгож байна. Энэ жил туршилтын журмаар ТЕГ-ын зарим ажилчид программыг туршиж байна. Үүнийг 2014 оноос эхлэн бүх шатны төрийн байгууллагуудад нэвтрүүлэн, ОУИТБС-ын тайланг цахим хэлбэрээр гаргуулахаар төлөвлөж байна.

Тайлан гаргахад тулгарч буй бэрхшээлийн тухайд **нэгдүгээрт**, Засгийн газрын тайлан гаргадаг төрийн албан хаагчид их солигддог, тайлангийн ач холбогдол, мөн чанарыг ойлгохгүйн улмаас тайланг жил бүр буруу, дутуу тайлагнах явдал давтагдаж байгаа тул үүнийг цаашид онцгойлон анхаарч тухайн ажлын байрны ажил үүргийн хуваарыт тусгайлан зааж өгөх шаардлагатай байна. **Хоёрдугаарт**, 2012 оны тайланд хамрагдах төрийн байгууллагуудын нэрсийн жагсаалт, компаниудын нэрсийн жагсаалтыг ажлын албанаас жил бүр батлаж байх нь нэгдсэн ойлголттой болж тайлан гаргах ажлыг шуурхай зохион байгуулахад чухал байна.

Ш.Цолмон: За баярлалаа. Асуух асуулттай хүн байна уу?

Д.Мөнхсайхан: Надад нэг асуулт байна. Манайхаас өгсөн нэрсийн дагуу ТЕГ-аас 20-иод аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг олж өг гэж манайд ирүүлсэн. Гэтэл манай газраас тэр мэдээлэл олдох боломжгүй, их хүндрэлтэй

байна. Тухайлбал аливаа нэгэн тусгай зөвшөөрөлтэй байгууллагын өмнөөс гүйцэтгэгч нь эсвэл өөр байгууллага манай дансанд төлбөр төлсөн нөхцөлд цаад байгууллагынх нь регистрийн дугаарыг мэдэж авах боломж алга. Хоёрдугаарт, иргэн хүн манайд үйлчлүүлээд төлбөр төлсөн тохиолдолд яах вэ? Ер нь ТЕГ-т бүх аж ахуйн нэгжийн регистрийн дугаар байдаггүй юм уу? Манайхаас түүнийг гаргуулдаг нь ямар учиртай юм бэ?

Д.Энхтуяа: АМГ-аас тусгай зөвшөөрөл эзэмшигч 1850 компанийн нэрсийг бидэнд гаргаж өгсөн. Танай газар тэдгээр байгууллагын регистрийн дугаарыг заавал бүртгэж авсан байх ёстой. Ер нь бол регистрийн дугаар гэдэг дахин давтагддаггүй, тухайн компанийн нэр зөрсөн ч регистрээр нь хөөж явдаг тул регистрийн дугаарыг заавал ашиглаж байх нь зүйтэй. Харин тэр нэг удаагийн төлбөр төлсөн иргэнийг ОУИТБС-ын тайланд тусгах шаардлагагүй юм.

Н.Дорждарь: Надад нэг асуулт байна. Регистрийн дугаараа өөрчилсөн аж ахуйн нэгж гэж байдаг уу. Бид сая нэгтгэлийн тайланд судалгаа хийж байхад нэр нь зөрөх, бүртгэлийн дугаар нь давхардах зүйлүүд ажиглагдаж байлаа.

Д.Энхтуяа: ААН болгон регистрийн дугаартай байдаг. Харин ААНэгжүүд хэлбэрээ өөрчлөх, нэрээ өөрчлөх зэрэг тохиолдууд гардаг бөгөөд үүнээс шалтгаалан зарим тохиолдолд тийм асуудал гарахыг үгүйсгэхгүй. УБЕГ-аас ААН-ийн бүртгэлийн дугаарыг давхардуулан олгосон цөөн тохиолдол байгаа.

Х.Батчимэг: ААН-ийн бүртгэлийн дугаар нь хүний регистрийн дугаартай нэгэн адил 7 оронтой тусгай дугаар байх ба энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй, харин нэр нь солигдож болно.

Д.Энхтуяа: Мөн тайланд хамрагдах байгууллагуудын нэрсийн жагсаалтыг албан ёсоор урьдчилан гаргаад бидэнд хүргүүлж байвал зүгээр гэсэн саналыг нэмж хэлье.

Ш.Цолмон: За баярлалаа. Тайлангаа гаргаагүй байгаа Сорьцын албан Гансүх даргын гарын үсэгтэй бичиг явуулах арга хэмжээ авъя. Өөр асуух зүйл байхгүй бол дараагийн асуудалдаа оръё.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Засгийн газрын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2012 оны тайланг хугацаанд нь гарган ажиллахыг холбогдох гишүүдэд зөвлөмж болгов.

2. ОУИТБС-ын 2012 оны тайлангаа гаргаагүй байгаа төрийн байгууллагуудад ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын албан шаардлага хүргүүлэхээр тогтов.

VIII. ХЭЛЭЛЦСЭН нь: Австралийн Сиднейд зохиогдох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын бага хуралд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлах

Ш.Цолмон: 2013 оны 5 дугаар сард зохиогдох бага хуралд оролцох төлөөлөгчдийн нэрсийн урьчилсан саналаар тодруулсан байгаа. Одоогоор нийт 13 хүн явахаас ажлын алба 5 хүний зардлыг гаргахаар болсон. Энэ тал дээр

нэмж хасах санал байна уу. Сая Оюу толгой ХХК-ийн Х.Лхамаа өөрийн нэрээ өгсөн байгаа. Төлөөлөгчдийн нэrsийн жагсаалтыг хавсаргав/

Н.Дорждарь: Уул нь Оюу толгой ХХК-ийн төлөөлөгчөөс асууя гэж бодож байсан юм. Гараад явчих шиг боллоо. Өмнөх хуралдаанд санал хэлж байсан. Нэгэнт Австралид очиж байгаа юм чинь тэр Рио Тинтогийн уурхайг үзүүлэх боломж байгаа эсэх талаар асууж байсан юм. Энэ талаар ямар хариу өгсөн юм бол?

Ш.Цолмон: Бидэнд хариу өгсөн байгаа. Оюу толгой ХХК-иас уурхайг үзүүлж болно, зохион байгуулалтын ажлыг хийж болно, харин уурхай хүртэлх зардлыг хариуцах боломжгүй гэж мэдэгдсэн байгаа.

Н.Дорждарь: Компаниудыг энэхүү аялалд түлхүү хамруулах хэрэгтэй байх. Ажлын албанаас ийм бага хурал болох гэж байгаа талаар компаниудад албан бичгээр мэдэгдэж, мэдээлэх нь зүйтэй байх.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Сиднейн Олон улсын бага хуралд оролцох төлөөлөгчдийн нэrsийг эцэслэн батлав.

2. Өөрийн байгууллагын зардлаар бага хуралд оролцох компаниудыг судлах, мэдээлэх, төлөөлөгчдийн визний болон бусад асуудлаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Ажлын албандаа даалгав.

Ажлын хэсгийн хурал 17 цагт 35 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ОУИТБС-ын ажлын хэсгийн
нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч

 Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүү,
захиргааны ажилтан



А.Огонтунгалаг